



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2025/001/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn
Өмнөговь аймаг
Даланзадгад хот
2025 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.14 № 160
танай _____-ны № _____-т

ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ЭРДЭНЭТӨГС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Эрдэнэс таван толгой” ХК, “Хангад-Эксплорэйшн” ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 3,193.8 сая төгрөгийн нүүрс хандивласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны зорилтод түвшинд орлогыг 12,405.3 сая, зарлагыг 15,731.7 сая, алдагдлыг 3,326.4 сая төгрөг байхаар баталж, гүйцэтгэлээр 14,990.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 15,197.0 сая төгрөг зарцуулж, 207.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх оноос буурсан байна.

4625020522

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 2024 оны А160 дугаар тушаалаар Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын зардлыг 2,038.9 сая төгрөг болгож 280.4 сая төгрөгөөр бууруулж тодотгон баталсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2024 оны 1 сарын 1	2024 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	56,768,703.21	55,261,278.60
1.1.02	Дансны авлага	637,126,234.20	260,723,801.33
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	4,249,119.19	4,249,119.19
1.1.06	Бараа материал	894,354,566.14	1,564,069,957.28
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	930,319,299.07	820,927,390.26
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,522,817,921.81	2,705,231,546.66
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,143,984,512.64	10,047,683,967.17
1.2.02	Биет бус хөрөнгө	1,693,362,820.01	1,695,538,865.45
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	281,255,274.62	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,118,602,607.27	11,743,222,832.62
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,641,420,529.08	14,448,454,379.28
2.1.1.01	Дансны өглөг	788,046,129.31	1,808,039,528.04
2.1.1.02	Цалингийн өглөг	8,721,759.78	6,267,068.87
2.1.1.03	Татварын өр	3,450,771,396.49	3,509,181,701.11
2.1.1.04	НДШ - ийн өглөг	1,839,066,364.07	1,367,679,813.42
2.1.1.05	Богино хугацаат зээл	5,429,287,369.00	5,144,787,369.00
2.1.1.06	Хүүний өглөг	1,173,573,482.47	1,175,935,037.47
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	946,844,923.38	1,303,463,657.38
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	632,062,638.85	358,912,430.90
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,268,374,063.35	14,674,266,606.19
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	4,348,756,066.00	4,071,994,122.10
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	356,654,135.00	356,654,135.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,705,410,201.00	4,428,648,257.10
2.2	Өр төлбөрийн нийт дүн	18,973,784,264.35	19,102,914,863.29
2.3.01	Өмч: - төрийн	8,337,595,020.45	8,337,595,020.45
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,808,076,252.49	4,808,076,252.49
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,655,056,500.00	1,655,056,500.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-19,133,091,508.21	-19,455,188,256.95
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-206,963,451.72
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-19,133,091,508.21	-19,248,224,805.23
2.3.11	Эздийн өмчийн дүн	-4,332,363,735.27	-4,654,460,484.01
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,641,420,529.08	14,448,454,379.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	5,928,163,250.31	6,770,124,673.62
02	Борлуулалтын өртөг	9,285,040,539.40	12,925,971,504.92
03	Нийт ашиг(алдагдал)	-3,356,877,289.09	-6,155,846,831.30
05	Хүүний орлого	131,294.60	2,973,914.85
07	Хандивын орлого	0.00	3,193,804,330.88
08	Бусад орлого	4,847,144,186.42	4,950,533,333.58
08.1	Орлогын дүн	4,847,275,481.02	8,147,311,579.31
09	Борлуулалт, маркетингийн зардал	4,287,729.99	5,251,982.70
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,171,637,693.86	1,551,787,588.42
11	Санхүүгийн зардал	14,905,519.18	0.00
12	Бусад зардал	935,715,288.66	713,872,280.16
12.1	Зардлын дүн	2,126,546,231.69	2,270,911,851.28
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	-56,893.91
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	72,540,545.46
17.1	Олз, гарзын дүн	0.00	72,483,651.55
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-636,148,039.76	-206,963,451.72
19	Орлогын татварын зардал	13,129.46	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-636,161,169.22	-206,963,451.72
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-636,161,169.22	-206,963,451.72

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	-19,133,091,508.21	-4,332,363,735.27
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-115,133,297.02	-115,133,297.02
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-206,963,451.72	-206,963,451.72
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	-19,455,188,256.95	-4,654,460,484.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,803,839,078.27	12,950,525,995.23
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,741,553,680.98	7,844,429,563.49
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,850,000,000.00	4,849,804,300.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,212,285,397.29	256,292,131.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,494,979,776.89	12,064,636,141.15
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,099,193,649.56	4,453,962,352.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,215,251,329.61	1,754,967,381.19
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,582,813,764.89	2,378,487,929.03
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	406,524,809.49	484,610,135.05
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,155,196,139.60	1,449,730,225.75
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	30,035,835.63
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	96,912,954.90	751,835,999.35
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	320,000.00	5,208,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	938,767,128.84	755,798,282.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	308,859,301.38	885,889,854.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	93,120.46	77,327,761.91
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	93,120.46	2,973,914.85
2.1.8	Бусад	0.00	74,353,847.06
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,390,000.00	680,225,040.60
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,390,000.00	666,365,040.60
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	13,860,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-50,296,879.54	-602,897,278.69
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,649,800,000.00	3,051,600,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,649,800,000.00	3,051,600,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,908,437,651.00	3,336,100,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,908,597,043.10	3,336,100,000.00
3.2.5	Бусад	-159,392.10	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-258,637,651.00	-284,500,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-75,229.16	-1,507,424.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,843,932.37	56,768,703.21
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,768,703.21	55,261,278.60

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
Боловсруулах эрчим хүч	ЦЭХ	мян.кВт.ц	25,080.0	15,784.4	9,295.60	
	ДЭХ	мян.Гкал	81.7	81.9	(0.17)	
Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч	хувиар	хувь	35.0	34.34	0.61	
	биетээр	мян.кВт.ц	8,766.7	5,420.7	3,345.98	
Түгээх эрчим хүч	ЦЭХ	мян.кВт.ц	16,313.3	10,363.7	5,949.62	
	ДЭХ	мян.Гкал	79.6	79.8	(0.17)	
Үүнээс: ДХ ОНӨААТҮГ-т худалдах ДЭХ		мян.Гкал	29.0	36.2	(7.25)	
		хувь	36.4	45.4	(9.01)	
Нийт орлого		сая төг	12,405.3	14,990.0	(2,584.72)	
Үйл ажиллагааны орлого		сая төг	7,472.9	6,770.1	702.74	
Үүнээс:	ЦЭХ	сая төг	3,262.7	2,075.2	1,187.45	
		ДЭХ	сая төг	4,210.2	4,694.9	(484.71)
	-Үүнээс ДХ ОНӨААТҮГ		сая төг	944.8	1,181.5	(236.71)
	- ДХ ОНӨААТҮГ эзлэх		сая төг	22.4	25.2	(2.72)
	Улсын төсвийн санхүүжилт		сая төг	3,090.9	4,408.9	(1,318.00)
	Үйл ажиллагааны бус орлого		сая төг	1,841.6	3,811.0	(1,969.45)
Нийт зардал		сая төг	15,731.7	15,197.0	534.70	
Үйл ажиллагааны зардал		сая төг	15,414.2	14,875.7	538.57	
Үүнээс:	түлш	сая төг	3,373.0	5,274.1	(1,901.14)	
	элэгдэл	сая төг	1,245.3	1,048.5	196.78	
	бусад тогтмол	сая төг	10,796.0	8,553.0	2,242.93	
Үйл ажиллагааны бус зардал		сая төг	317.5	321.4	(3.87)	
Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	(3,326.4)	(207.0)	(3,119.42)	
Татварын дараахь ашиг /алдагдал/		сая төг	(3,326.4)	(207.0)	(3,119.42)	
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төг	2.105	2.245	(0.14)	
Нийт авлага		сая төг	511.8	277.3	234.58	
Үүнээс:	ЭХ-ний	сая төг	194.7	140.9	53.84	
	Бусад	сая төг	317.1	136.4	180.75	
Нийт өглөг		сая төг	16,870.4	19,102.9	(2,232.51)	
Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая төг	13,462.3	14,674.3	(1,211.93)	
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	3,408.1	4,428.6	(1,020.58)	
Нийт ажиллагсдын тоо		тоо	175.0	154.0	21.00	
Нийт цалингийн сан		сая төг	7,159.6	4,995.6	2,164.04	
Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	1,270.8	1,364.0	(93.20)	
	ДЭХ	кг/Гкал	248.9	238.7	10.20	
Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	2,038.9	1,037.5	1,001.39	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,103.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,103.6 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан.

Залруулсан алдаа:

- Биет бус хөрөнгөд 11.7 сая төгрөгийн хуримтлагдсан хорогдлыг тооцож санхүүгийн тайланд тусгаагүй тайлант үеийн үр дүнг буруу илэрхийлсэн
- Мөнгөн гүйлгээний тайланд хүлээн авсан хүүгийн орлогыг 0.9 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн
- Орлогын дэлгэрэнгүй тайланд данснаас хассан хөрөнгийг худалдан борлуулсны орлого 72.5 сая төгрөгийг олзоор тусгаагүй, бусад орлого дансанд тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд зарцуулсан 599.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зардалд тайлагнаагүй
- Ширэм хайлуулах үйлдвэр болон цайны газрын зардал 332.3 сая төгрөгийг орлогын дэлгэрэнгүй тайланд бусад ашиг/алдагдал/ дансанд тайлагнасан
- Даланзадгадын ДЦС-ыг усан халаалтын зуухаар өргөтгөх техник эдийн засгийн үндэслэл, Ахуйн байрны зураг төсвийг тус тус бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгээгүй байна.

Дээрх алдаанууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 2.Биет бус хөрөнгө, 5.Хүүний орлого, 2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ (в)Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага, 14.Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз), 19.3.Бусад ашиг (алдагдал), санхүүгийн тайлагналын толилуулга, үнэн зөв байх, иж бүрэн байх, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 137.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс зөрчил давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 137.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

Нийцлийн аудитын асуудлаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Олон жилийн насжилттай эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актгүй 52.1 сая төгрөгийн авлага, 112.1 сая төгрөгийн өглөгт, мөн гэрээт ажлын урьдчилгааны 458.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлд тус тус холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өгсөн зөвлөмж: Салбарын дотоод аудитын нэгжээрээ дамжуулан холбогдох асуудлыг шийдвэрлэх, дотоод хяналтыг сайжруулж ажиллах

Илрүүлэлт 2: Хамтын гэрээнд заасны дагуу олгосон зарим нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжид хувь хүний орлогын албан татвар ногдуулж суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж", Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хамтын хэлэлцээр, гэрээ, хөдөлмөрийн дотоод журам зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжаас хууль тогтоомжийн дагуу татвар суутгаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Биет бус хөрөнгөд 11,683.9 мянган төгрөгийн хуримтлагдсан хорогдлыг тооцож санхүүгийн тайланд тусгаагүй тайлант үеийн үр дүнг буруу илэрхийлсэн байна.	1	11,683.9	1	11,683.9			1	11,683.9				
Мөнгөн гүйлгээний тайланд хүлээн авсан хүүний орлогыг 928.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	1	928.0			1	928.0	1	928.0				
Орлогын дэлгэрэнгүй тайланд данснаас хассан хөрөнгийг худалдан борлуулсны орлого 72,540.6 мянган төгрөгийг олзоор тусгаагүй, бусад орлого дансанд тайлагнасан байна.	1	72,540.6			1	72,540.6	1	72,540.6				
Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд зарцуулсан 599,511.1 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зардалд тайлагнаагүй байна.	1	599,511.1			1	599,511.1	1	599,511.1				
Ширэм хайлуулах үйлдвэр болон цайны газрын зардал 332,319.9 мянган төгрөгийг орлогын дэлгэрэнгүй тайланд бусад ашиг/алдагдал/ дансанд тайлагнасан байна.	1	332,319.9			1	332,319.9	1	332,319.9				
Даланзадгадын ДЦС-ыг усан халаалтын зуухаар өргөтгөх техник эдийн засгийн үндэслэл, Ахуйн байрны зураг төсвийг тус тус бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгээгүй байна	1	86,609.1	1	86,609.1			1	86,609.1				
Дүн	6	1,103,592.6	2	98,293.0	4	1,005,299.6	6	1,103,592.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцруулж мэдээлсэн, хөрөнгө, мөнгө зарцуулсан шийдвэрийг бүрэн мэдээлж ажиллаагүй байна	1	102,370.7					1	102,370.7
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө төсөвт өртгийг бодитой тооцоолоогүй, төлөвлөгөөнд тусгаагүй Pеле SEL7518, төмөр сейф, Notebook Raider GE76 12 UE, Ipad 12.9inch 256gb, Өнгөт принтер /Epson L3256/, шкаф /Локер/, зөөврийн компьютер /lenovo i3/ зэрэг нийт 33,828.9 мянган төгрөгийн 8 ш хөрөнгө бэлтгэсэн байна.		33,828.9					1	33,828.9
Тендер шалгаруулалтын хувийн хэргийг шалгахад үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлгүй, гишүүд ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудас бүрэн хөтлөөгүй, худалдан авах гэрээг тус тус хавсаргаагүй тендерийн баримт бичгийн бүрдэл хангаагүй байна.	1	0			1	0		
Нийт дүн	3	136.199.6			1	0	2	136,199.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Олон жилийн насжилттай эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актгүй 52,143.5 мянган төгрөгийн авлага, 112,083.5 мянган төгрөгийн өглөгт, мөн урьдчилж төлсөн зардалд гэрээт ажлын урьдчилгаа 458,962.5 мянган төгрөгийн дансны үлдэгдэлд тус тус холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна	1	0					1	0				
Хамтын гэрээнд заасны дагуу олгосон зарим нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжид хувь хүний орлогын албан татвар ногдуулж суутгаагүй байна.	1	811.1					1	811.1				
Дүн	2	811.1					2	811.1				